



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 459

Улаанбаатар хот

Хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Засгийн газрын 10 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6 нэрийн нийт 39,669,942.52 (гучин есөн сая зургаан зуун жаран есөн мянга есөн зуун дөчин хоёр төгрөг тавин хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Лхагва нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах ажлыг зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001460

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2021 оны 10 дугаар сарын 19-ний
өдрийн 49 дугаар тогтоолын хавсралт

"Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй акталж данснаас хасах хөрөнгийн жагсаалт

№	Биет бус хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон огноо	Хэм жих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/	Балансын, Хуримтлагдсан элэгдлийн дүн /төгрөгөөр/
1	Clering системийн шинэчлэл 1	2006-06-30	ш	1	1,402,000.00	1,402,000.00
2	Clering системийн шинэчлэл 2	2006-11-30	ш	1	931,200.00	931,200.00
3	Clering системийн шинэчлэл 3	2007-02-26	ш	1	3,031,056.00	3,031,056.00
4	Clering системийн шинэчлэл 4	2007-12-30	ш	1	1,305,686.52	1,305,686.52
5	Удирдлагын хяналтын программ	2009-06-30	ш	1	30,000,000.00	30,000,000.00
6	Динамик оффис систем	2017-07-25	ш	1	3,000,000.00	3,000,000.00
				6		39,669,942.52
				6 (зургаа)	39,669,942.52 (гучин есөн сая зургаан зуун жаран есөн мянга есөн зуун дөчин хоёр төгрөг тавин хоёр мөнгө)	